



МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

/2025-2028 он/

АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Мягмарсүрэн. Сургалтын албаны менежер
Ажлын хэсгийн нарийн бичиг:	Ж.Норжмаа. Арга зүйч багш
Удирдлага, зохион байгуулалтын баг:	П.Мөнхцоож. Захиргаа аж ахуйн менежер Д.Өнөржаргал. Дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ахлах ажилтан Б.Алтанцэцэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ахлах ажилтан
Сургах ба сурах үйл ажиллагааны баг:	Д.Мөнхбаяр. Арга зүйч багш Э.Ану-Үжин. Нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч Ш.Ариунзул. Цахим сургалтын агуулга хөгжүүлэлт, сургалтын нөөц хариуцсан ажилтан
Хүний нөөцийн хөгжлийн баг:	М.Чулуунцэцэг. Санхүү, няравын багш Д.Мөнхцэцэг. Математикийн багш Б.Анхцэцэг. Захирлын туслах бичиг хэргийн ажилтан
Нийгмийн түншлэлийн баг:	Т.Халиунаа. Нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч А.Шинэбаяр. Монгол хэл, уран зохиолын багш Б.Хишигжаргал. Физикийн багш
Санхүү, эдийн засгийн баг:	Л.Сарангуа. Ерөнхий нягтлан бодогч Б.Золзаяа. Номын санч Д.Мөнхцэцэг. Нярав
Материаллаг бааз, техник технологийн баг:	М.Баярмаа. Уул уурхайн технологийн багш Т.Эрхэмбаяр. Аргазүйч багш Г.Батзул. Цахилгааны мэргэжлийн багш
Суралцагчдад чиглэсэн үйлчилгээний баг:	Д.Гэрэлцэцэг. Нийгмийн ажилтан М.Дэлгэрням. Химийн багш Б.Алтанцэцэг. Сургуулийн эмч
Стратегийн бодлогын зөвлөх	Г.Энхбат. МУ-н зөвлөх багш, ХАБ-ын зөвлөх, Стратеги дизайн хөгжүүлэгч
Стратегийн бодлогын зөвлөх	Г.Нямхатан. Тэргүүлэх багш, стратеги болон менежментийн зөвлөх, докторантур

АГУУЛГА

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
Нэг. Хамт олны чадамжийн өөрийн үнэлгээний судалгааны тойм	6
Хоёр. Стратегийн бэлэн байдлын судалгааны тойм	7
Гурав. Мандатын шинжилгээ	9
Дөрөв. Хүчин зүйлсийн зураглалын шинжилгээ	22
Стратегийн гол зорилтыг тодорхойлох мексоны 5х5 шинжилгээ	22
Мексоны асуулт 1. Хамгийн их нөлөөлөх гадаад орчны 5 боломж	22
Мексоны асуулт 2. Гадаад орчноос нөлөөлөх хамгийн аюултай 5 эрсдэл	23
Мексоны асуулт 3. Дотоод орчны хамгийн давуу 5 хүчин зүйлс	23
Мексоны асуулт 4. Дотоод орчны хамгийн сул 5 хүчин зүйлс	23
Дөрөв. Хамгийн чухал гэж сонгосон SWOT шинжилгээний 5 хүчин зүйлс:	23
Тав. Алсын хараа, эрхэм зорилго	24
Зургаа. Стратегийн зорилго, зорилтууд	25
Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги	26
Найм. Стратегийн уялдаа холбоо, хэрэгжүүлэх арга зүй	50
8.1. Стратегийн замын зураг	50
8.2. Стратеги: менежментийн нэвтрэлт, (хэрэгцээ)	51
Ес. Стратегийн удирдлага, хяналт үнэлгээ	52
9.1. Удирдлага, хяналт, үнэлгээ	52
9.2. Хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бүтэц	52
Арав. Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үеийн эрсдэл	53
10.1. Гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ	53
10.2. Эрсдэлийн хариу үйлдлийн төлөвлөлт	54
Арван нэг. Санхүүгийн нөөц	54
Арван хоёр. Сургуулийн үйл ажиллагааны орлогын өсөлтийн хувь хэмжээ	55
Хавсралт №1 Стратегийн бэлэн байдлын судалгаа ба асуудал, зорилгын модны шинжилгээ	
Хавсралт №2 Говьсүмбэр ПК-н чадамжийн өөрийн үнэлгээний судалгаа	
Хавсралт №3 Говьсүмбэр ПК-н SWOT ба Мексоны 5Х5 шинжилгээ	
Хавсралт №4 Говьсүмбэр ПК-н нэгдсэн кросс SWOT /TWOS шинжилгээний матриц	

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Магадлан итгэмжлэгдсэн Говьсүмбэр Политехник коллеж нь Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн зорилго болох нийгэм эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, үндэсний мэргэшлийн хүрээ, шаталсан бүтцэд нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулж байна.

ЗГХЭГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн “Аргачлал, загвар батлах тухай”, 2020 оны 100 дугаар тушаалд “Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлгийн 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэсэн заалтын дагуу Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмыг хэрэгжүүлэх аргачлал, загварчлалыг үндэслэн стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг чиглэл болгон ашигласан. Үүнд:

1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөдөлмөрийн тухай хууль
4. Боловсролын ерөнхий хууль
5. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль
6. 2020 оны 05 сарын 13-ны өдрийн МУИХ-ын 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай
7. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
8. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
9. Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030
10. Монгол улсын Дунд хугацааны /2020-2025/ тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл
11. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
12. Говьсүмбэр аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр
13. Сургуулийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан

Сургуулийн түүхэн замнал


**Хамт олноос өгсөн 2019-2023 оны стратегийн зорилгын
биелэлтийн ерөнхий үнэлгээ**

№	Говьсүмбэр ПК-ийн 2019-2023 оны стратегийн зорилго, зорилт	Үнэлгээ
1	УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ (Удирдлага, засаглал, зохион байгуулалтыг оновчтой болгож орчин үеийн менежментийн хандлагыг нэвтрүүлнэ)	71,3
2	СУРГАХ БА СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ (Сургалт, судалгаа, инновацыг хөгжүүлэх замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.)	72,7
3	НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛГО, ЗОРИЛТ (Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.)	66,7
4	ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ (Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, тогтвортой байдлыг хангах.)	69,6
5	МАТЕРИАЛЛАГ БААЗ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ (Техник, технологийн хөгжлийн бодлого хэрэгжүүлж бүтээмжийг нэмэгдүүлнэ.)	85,9
6	САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ (Санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын менежментийг хэрэгжүүлэх замаар сургуулийн өрсөлдөх чадвар, санхүүгийн чадавхыг дээшлүүлнэ.)	70,9
7	НИЙГМИЙН ХАМГААЛАЛ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ (Нийгмийн хариуцлагыг цогц байдлаар хэрэгжүүлж нийгэм, хамт олонд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлнэ.)	74,9
Ерөнхий үнэлгээ		70,6

Нэг. Хамт олны чадамжийн өөрийн үнэлгээний судалгааны тойм

Судалгааг ОУХБ-ын ИТС стратегийн дизайн боловсруулах, тогтолцооны чанарыг үнэлэх аргачлал болон Удирдлагын академийн “Бизнесийн болон төрийн байгууллагын менежментийн чадамжийн ерөнхий төлөв”-ийг тодорхойлсон судалгаа, магадлан итгэмжлэлийн чанарын баталгаажилтын хийх аргачлал зэргийг ашиглан Говьсүмбэр ПК-н менежментийн чадамжийн өөрийн үнэлгээг 1 бүлэг 10 багц асуулт бүхий 7 бүлгийн 70 шалгуур үзүүлэлтээр “Google form” ашиглан мэдээллийг цуглуулж статистик боловсруулалт хийсэн.

Говьсүмбэр ПК-н стратеги төлөвлөгөө боловсруулах 2024 оны үеийн тус ПК-н менежментийн ерөнхий чадамжид хамт олноос авсан судалгааны үнэлгээ 78,8 хувь буюу сайн дүнтэй гарсан байна.



Дээрх графикаас харахад захиргаа ба удирдлага, сургах, сурах үйл ажиллагаа, суралцагчдад чиглэсэн үйлчилгээ, санхүү, нөөц ашиглалт 70-с дээш хувиар сайн. Харин бусад үндсэн 3 үзүүлэлт 70-с доош хувь буюу хангалттай хэмээн үнэлэгдсэн байна.

1	Захиргаа ба удирдлага	Сайн (+)
2	Сургах, сурах үйл ажиллагаа	Сайн (+)
3	Хүний нөөцийн чадавх	Хангалттай
4	Мэдлэг, инновацын чадавх	Хангалттай
5	Нийгмийн түншлэл	Хангалттай
6	Санхүүгийн нөөц ашиглалтын чадавх	Сайн
7	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	Сайн (+)
Дундаж үнэлгээ		Сайн

Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох журам, дүрмийн хүрээнд техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагааг говийн бүс нутагт төдийгүй үндэсний хэмжээнд жишиг байдлаар хөгжүүлэх, бий болсон чадавхыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Говьсүмбэр ПК-н хамт олноос сургуулийн ерөнхий чадамжийн өөрийн үнэлгээний үндсэн 7 үзүүлэлтийн дундаж 70,6 хувь буюу “САЙН” гэж үнэлэгдсэн байна.

Иймд ПК-н хамт Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Бүсчилсэн хөгжлийн бодлого, Говийн бүс болон Говьсүмбэр аймагт хийгдэх хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүтээн байгуулалтын ажилтай уялдсан сургуулийн стратегийн хөгжлийн 2024-2028 оны зорилго, зорилтуудыг тодорхойлон хэрэгжүүлэх нь зүйтэй.

Мөн сургуулийн материаллаг орчин, цахим технологи, сургалтын шинэ арга хэрэгслийг багш нар эзэмшин ТМБС-ын салбарт жишиг болохуйц үр дүн, үр ашигтай арга хэмжээг түгээн дэлгэрүүлэх замаар говийн бүс болон үндэсний хэмжээнд тэргүүлэгч хамт олон болох нөхцөл бүрдсэн байна.

Хоёр. Стратегийн бэлэн байдлын судалгааны тойм

Говьсүмбэр Политехник коллежийн 2024 оны стратегийн бэлэн байдлын судалгаанд 50,8 хувь нь багш, 49,2 хувь нь ажилтан, албан хаагчид тус судалгаанд оролцсон байна.

Боловсролын түвшнээс харахад нийт багш ажилчдын дунд магистр 32,2%, бакалавр 42,4%, дипломын болон тусгай дунд 25,4% байна.

Сургуулийн одоогийн эрхэм зорилго, алсын хараа бүрэн биелсэн 22%, өөрчлөх сайжруулах шаардлагатай гэж 41,1% үзжээ. Сургуулийн удирдлага, хамт олон стратеги төлөвлөгөө боловсруулах сургалт, дадлага ажлын хүрээнд өмнөх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийгдэх дүн шинжилгээнд үндэслэн сургуулийнхаа алсын хараа, үнэт зүйл, соёлын чиглэлээр сайжруулалт хийх, шинэчлэх асуудлыг Мексоны 5X5 шинжилгээ болон хамт олон, стратегийн төлөвлөгөө боловсруулах багийн гишүүдийн саналд үндэслэн шийдвэрлэх хэрэгцээ үүссэн байна.

Бүтэц, зохион байгуулалт хувьд оновчтой гэж 33,9%, алба, тэнхимийн чиг үүргийг шинэчлэх шаардлагатай гэж 25,4%, оновчтой бус шинэ бүтэц, зохион байгуулалтад орох 27,1% байна. Үүнээс харахад сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг боловсролын багц хуулийн хүрээнд олон улсын хөгжлийн чиг хандлага, бүс нутгийн онцлогт нийцүүлэн шинэчлэх, ТМБС-ын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлж дүгнэх, сургуулийн байнгын, тогтвортой ажиллагааг хангах замаар говийн бүс нутаг, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэй ажилтан бэлтгэх эрэлт, шаардлагад нийцүүлэн шинэчилж болно.

Менежментийн чиг үүргүүдээс сайжруулах шаардлагатай гэж бүтэц зохион байгуулалт 37,1%, төлөвлөлт 35,4%, сайжруулалт 20,1%, манлайлал 25,3% хэмээн үнэлсэн байна. Иймд Говьсүмбэр ПК-н удирдах зөвлөлөөр шинэ стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтад хяналт-шинжилгээ, дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, сургуулийн санхүү, нөөцийн чадавхыг дээшлүүлэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн механизмыг хэрэгжүүлэх чадварлаг хүний нөөц бүрдэл бүхий бүтцийг батлуулах анхаарал хандуулах шаардлага үүссэн байна.

Сургуулийн үйл ажиллагаанд нэвтэрч байгаа дижитал сургалтын орчныг ашиглан алба, тэнхим, нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах чанарын удирдлагын тогтолцоо, дотоод чанарын аудит, хяналт үнэлгээг үйл ажиллагаанд нэвтрүүлэн арга хэмжээг хэмжээслүүлэх, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Сургуулийн дунд шатны менежментийн чиг үүргийг хэрэгжүүлэгч мэргэжилтэн нарын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, мэргэшсэн мэргэжилтний манлайллыг дээшлүүлэн хамт олныг байгууллагадаа итгэх итгэлийг төгөлдөршүүлэхэд анхаарах нь чухал байна.

Байгууллагын зорилго, зорилт нь хэрэгжих бодит боломжтой байхаар тодорхойлох, хэрэгжилтийг хянах, үнэлэх, боловсронгуй болгох үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах шаардлагатай байна.

Удирдлагын зүгээс төлөвлөлтийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн стратегийн хөгжлийн 2024-2028 оны зорилтуудыг байгууллагын чадамжийн судалгаа, стратегийн бэлэн байдлын судалгаа, шинжилгээнд тулгуурлан хэрэгжүүлдэг механизм бүрдүүлэн сургалтын чиглэлийг тодорхойлох, чанарыг дээшлүүлэх, зах зээлийн эрэлтэд нийцүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Сургуулийн үйл ажиллагааг үр өгөөжтэй удирдлагаар хангаж чадахуйц мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулж, тасралтгүй хөгжүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын байгууллага нь үндсэн зорилт, зорилгоо хэрэгжүүлэх эрх мэдлийн хуваарилалт, үүрэг хариуцлагыг оновчтой төлөвлөж, чанар, үр ашгийг тооцон ил тод нээлттэй байдлаар урамшуулах ажиллах шаардлага байгаа нь харагдаж байна.

**ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль	
Нийтлэг мөрдөх хууль	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Үндсэн хууль

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Долоодугаар зүйл.

1.Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

2.Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.

Арван зургаадугаар зүйл.

4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

7/сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.

8/соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль

№	Чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогч /Хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт/
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
1. Удирдлага, чанарын баталгаажилтын хөгжлийн зорилт			
1.1	Менежментийн чадамжийг дээшлүүлэх	Сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах	26.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 9.8.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг тухайн сургалтын байгууллагын дүрмээр тогтооно. 9.9.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хүн амын төвлөрөл, бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн төрөлжүүлж болно. 9.12.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага харьяалалдаа чадамжийн төв, салбар дундын дадлагын бааз, гарааны компани, бизнес инкубатор төв, туслах аж ахуйтай байж болно.
1.2	Чанарын баталгаажилт	Магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг мөрдөх	8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.13-т заасан Боловсролын чанарын баталгаажуулалт магадлан итгэмжлэлийн байгууллага мөн хуулийн 26.1.8-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ. 8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ. 8.6.Боловсролын ерөнхий хуулийн 25.1.3-т заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ. 8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн

			35.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
2. Сургах ба сурах үйл ажиллагааны хөгжлийн зорилт			
2.1	Сургалцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх	3.1.1."чадамжид суурилсан сургалт" гэж ажил, мэргэжлийн стандартад тодорхойлсон чадамж эзэмшихэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг; 3.1.2."чадамж" гэж мэдлэг, ур чадвар, хандлагын цогцыг; 3.1.3."чадамжийн нэгж" гэж тодорхой ажил, мэргэжлийн чадамж эзэмшихэд чиглэсэн харилцан уялдаа бүхий сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүнийг; 3.1.4."мэргэшил" гэж хөдөлмөр эрхлэхэд шаардагдах чадамжийг; 3.1.5."мэргэшлийн түвшин" гэж ажил мэргэжлийн стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг; 3.1.7."мэргэжлийн боловсрол" гэж мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж эзэмших боловсролын түвшнийг; 3.1.8."техникийн боловсрол" гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж эзэмших боловсролын түвшнийг; 6.8.Сургалтын хөтөлбөрийг түншлэлийн оролцоог хангаж ажил, мэргэжлийн стандартад нийцүүлэн энэ хуулийн 9.1-д заасан сургалтын байгууллага боловсруулна. 11.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын хичээлийн жилийн эхлэх, дуусах, үргэлжлэх хугацаа, зохион байгуулалтыг сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулна. Тухайн салбар, мэргэжлийн онцлогоос хамаарч уян хатан зохицуулалт хийж болно. 7.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын стандарт нь Боловсролын ерөнхий хуулийн 16.1-д <u>/16.1.Боловсролын стандартаар сургалтын орчин, эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн ажил мэргэжлийн чадамж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих үндсэн шаардлагыг тодорхойлно./</u> зааснаас гадна мэргэжлийн болон техникийн боловсролын үнэлгээнд тавих нийтлэг шаардлагыг тодорхойлно.
2.2		Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацыг хөгжүүлэх	15.1.1.өөрийн судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үр дүнд бий болсон бүтээл, бүтээгдэхүүний орлогоос хувь, ногдол ашиг хүртэх; 15.2.1.инновац, шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтад нэвтрүүлэх, сургалтын идэвхтэй, шинэлэг арга зүйг үр өгөөжтэй ашиглах; 25.1.7.эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, инновац хөгжүүлэх, онол практикийн хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах; 25.1.8.судалгаа, эрдэм шинжилгээний ажлын сан бүрдүүлэх, шинэ бүтээлийг патентлуулахад дэмжлэг үзүүлэх;
2.3		Сурах бичиг, сургалтын орчныг хөгжүүлэх	15.2.3.сургалтын хөтөлбөрийг боловсруулах, нэгж хичээлийн төлөвлөлт хийх, дадлага сургалтын удирдамж боловсруулах, шинэчлэх, сургалтад ашиглах; 27.5.9.сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах орчин нөхцөл, материаллаг нөөцөөр хангах ажлыг удирдан зохион байгуулах;
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
3. Нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх зорилт			
3.1	Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн	МБС-ын салбар дахь хамтын ажиллагааны хүрээг	11.3.Хосмог сургалтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасныг үндэслэн зохион байгуулна. 23.1.6.мэргэжлийн боловсрол, сургалтын тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг

	хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	өргөжүүлэх	боловсруулж батлуулах; 27.5.3.нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбооны оролцоог дэмжих;
3.2		МБС-ын чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	27.5.4.гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр, судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах;
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
4. Хүний нөөц, мэдлэг, инновацыг хөгжүүлэх зорилт			
4.1.	Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх	Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг сайжруулах	14.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна сургалтын байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд оролцох, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. 14.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш тухайн мэргэжлийн чиглэлээр бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт гурваас доошгүй жил ажилласан туршлагатай, мэргэшлийн өндөр ур чадвартай, багшлах эрхийн гэрчилгээтэй байна. 14.3.Техникийн боловсролын сургалтын байгууллагын багш тухайн мэргэжлийн чиглэлээр магистр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй,үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт таваас доошгүй жил ажилласан туршлагатай, мэргэшлийн өндөр ур чадвартай, багшлах эрхийн гэрчилгээтэй байна.
4.2		Мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх	14.4.Багшийн мэдлэг, ур чадварын үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, сургалтын байгууллагатай хамтран дөрвөн жил тутам зохион байгуулна. 15.1.5.шилдэг туршлагаа түгээн дэлгэрүүлэх; 15.1.6.ажлын гүйцэтгэл, үр дүнгээ үнэлүүлэх; 15.1.7.ажил, мэргэжлийн стандарт боловсруулахад оролцох.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
5. Санхүү, эдийн засгийн хөгжлийн зорилт			
5.1	Сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Материаллаг баазын ашиглалт, хэрэглээг сайжруулах	26.5.1.сургалтын, судалгаа шинжилгээний, үйлдвэрлэлийн болон үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг тогтоох; 27.5.5.батлагдсан төсөв, өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогыг үр ашигтай зарцуулах; 27.5.9.сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах орчин нөхцөл, материаллаг нөөцөөр хангах ажлыг удирдан зохион байгуулах;
5.2		Санхүүгийн менежментийг сайжруулах, замаар мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	23.1.2.мэргэжлийн өөрийн өртөг тооцох аргачлалыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах; 26.5.1.сургалтын, судалгаа шинжилгээний, үйлдвэрлэлийн болон үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг тогтоох;
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
6. Нийгмийн хамгаалал, суралцагчдад чиглэсэн хөгжлийн зорилт			
6.1	Нийгмийн хамгааллыг сайжруулах	Нийгмийн хамгаалал, хариуцлагын сан үүсгэх ашиглах	16.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш Боловсролын ерөнхий хуулийн 13.3-т зааснаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана: 16.1.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай

			хуулийн 28.1.9-д заасан хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангагдах; 16.1.2.Мэргэжлийн боловсролын сургууль, ПК-н багшид таван жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгох; 16.1.3.Мэргэжлийн боловсролын сургууль, ПК-н захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, арга зүйч, номын санч, эмч, хоол зүйч, тогооч, сэтгэл зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа боловсролын сургалтын байгууллагаас олгох.
6.2	Суралцагчийн үйлчилгээг сайжруулах	Сурагчдын ая тухтай сурч, амьдрах нөхцөлийг хангах	9.16.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дотуур байртай байж болно. Дотуур байранд тавих шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно. 10.1.9.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, жендерийн мэдрэмжтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх; 15.2.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3.4, 6.3.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх. 17.3.Суралцагч элссэн хөтөлбөрөөр суралцах хугацаандаа тухайн чиглэлийн мэргэжлийн бусад хөтөлбөрт суралцаж, хос мэргэжил эзэмшиж болно. 17.4.Суралцагч энэ хуулийн 17.3-т заасан ижил чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт хамрагдах тохиолдолд сургалтын төлбөр төлөх бөгөөд тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

Боловсролын ерөнхий хууль

№	Чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогч /Хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт/
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
1. Удирдлага, чанарын баталгаажилтын хөгжлийн зорилт			
1.1	Менежментийн чадамжийг дээшлүүлэх	Сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах	3.1.3."боловсролын түвшин" гэж сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг; 7.2.Албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол гэсэн түвшинтэй байна. 17.11.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
1.2	Чанарын баталгаажилт	Магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг мөрдөх	3.1.15."мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц" гэж хүний эзэмшсэн чадвар, чадамжийг ангилан төрөлжүүлж, түвшнээр нь эрэмбэлсэн бүтцийг; 3.1.20."чанарын баталгаажуулалт" гэж боловсрол, сургалтын чанарыг хууль тогтоомжид заасан шаардлага, чанарын шалгуур, стандартад нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх, сайжруулах, үр дүнг баталгаажуулах үйл явцыг; 3.1.22."магадлан итгэмжлэл" гэж боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанар нь эрх бүхий байгууллагаас тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэхэд мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх үйл явцыг;

			17.13.Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага нь боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг эрхлэн хариуцах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
2. Сургах ба сурах үйл ажиллагааны хөгжлийн зорилт			
2.1	Сургалцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх	3.1.2."боловсролын агуулга" гэж боловсролын тухайн түвшинд суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, төлөвшлийн цогцыг; 3.1.6."мэргэжлийн чиглэл" гэж мэргэжил эзэмших хөтөлбөрийн ангиллыг; 3.1.13."сургалтын хөтөлбөр" гэж суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшил, зорилго, зорилт, үнэлгээ, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүнийг тусгасан цогц баримт бичгийг; 3.1.19."боловсролын үнэлгээ" гэж боловсрол, сургалтын үйл ажиллагааны явц, үр дүнгийн мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэх, баталгаажуулах, цахим технологи ашиглан тайлагнах үйл явцыг; 3.1.21."хөндлөнгийн үнэлгээ" гэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаас үнэлэх үнэлгээг; 9.1.Боловсролын баримт бичиг нь суралцагчийн эзэмшсэн боловсролын түвшин, мэргэжил болон чадамжийн түвшнийг гэрчилсэн албан ёсны баталгаа мөн. 14.2.Албан боловсролын агуулгыг мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын, дипломын, бакалавр, магистр, докторын гэж ангилах бөгөөд агуулгыг сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.
2.2		Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацыг хөгжүүлэх	10.1.6.сургалтын чанар, сургалтын хөтөлбөр, агуулгын талаар санал, хүсэлт илэрхийлэх, судалгаа, шинжилгээний ажилд оролцох; 14.5.Боловсролын сургалтын байгууллага нь шинжлэх ухаан, соёл урлаг, спортын байгууллагатай хамтран бүх түвшний сургалтын хөтөлбөр, агуулгын дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж болно.
2.3		Сурах бичиг, сургалтын орчныг хөгжүүлэх	13.5.Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага нь багшийг сургалтын үйл ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалаар хангана.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
3. Нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх зорилт			
3.1	Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	МБС-ын салбар дах хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх	34.1.Мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургууль, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын сургууль болон Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулсан боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага нь удирдах зөвлөл байна.
3.2	ажиллагааг өргөжүүлэх	МБС-ын чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	37.4.Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн сургалтын орчин, үйл ажиллагааг дэмжсэн туслах аж ахуйтай байж болох бөгөөд түүнээс олсон орлогоо зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч хэрэгжүүлнэ.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
4. Хүний нөөц, мэдлэг, инновацыг хөгжүүлэх зорилт			
4.1	Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх	Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг сайжруулах	12.1.Багш, ажилтан нь боловсролын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
4.2		Мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх	12.6.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр энэ хуулийн 5.1.4-т заасан зарчимд үндэслэсэн, Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандартад нийцсэн байна. 12.9.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.8-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
5. Санхүү, эдийн засгийн Говьсүмбэрийн зорилт			
5.1	Сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Материаллаг баазын ашиглалт, хэрэглээг сайжруулах	16.1.Боловсролын стандартаар сургалтын орчин, эрүүл ахуй, аюулгүй байдал, багшийн ажил мэргэжлийн чадамж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих үндсэн шаардлагыг тодорхойлно. 16.2.Боловсролын стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага батална. 20.1.3.стандарт, техникийн зохицуулалтад заасан шаардлага хангасан хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, дадлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;
5.2		Санхүүгийн менежментийг сайруулах, замаар мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	5.2.Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтална. 20.1.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
6. Нийгмийн хамгаалал, суралцагчдад чиглэсэн хөгжлийн зорилт			
6.1	Нийгмийн хамгааллыг сайжруулах	Нийгмийн хамгаалал, хариуцлагын сан үүсгэх ашиглах	11.4.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгож болно. 11.5.Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгоно. 13.3.1.хөдөлмөрийн онцлогийг харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15 өдөр, багш, багшийн туслах, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт олгох; 13.3.4.төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох; 13.3.6.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн

			дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах.
6.2	Суралцагчийн үйлчилгээг сайжруулах	Сурагчдын ая тухтай сурч, амьдрах нөхцөлийг хангах	13.2.8.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 16.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын сургууль, ПК-н дотуур байр, мэргэжлийн боловсролын сургууль, ПК-н дадлага сургалтад хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсрол эзэмшихэд шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчинд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасан холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөнө. 39.1.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

Хөдөлмөрийн тухай хууль

№	Чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогч /Хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт/
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
1. Удирдлага, чанарын баталгаажилтын хөгжлийн зорилт			
1.1	Менежментийн чадамжийг дээшлүүлэх	Сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах	17.1.Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн стандартыг батлах, мэргэшлийн түвшнийг тогтоон хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл явц мэргэшлийн үндэсний хүрээнд хамаарна.
1.2	Чанарын баталгаажилт	Магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг мөрдөх	17.5.Ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоод хамтран ажил мэргэжлийн стандартыг боловсруулна. 17.6.Ажил мэргэжлийн стандартаар хөдөлмөрийн нөхцөл, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтооно.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
2. Сургах ба сурах үйл ажиллагааны хөгжлийн зорилт			
2.1	Сургалцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх	63.2.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад суралцах цаг, эзэмших мэргэжил, ажлын байран дээр ажиллах цаг, эзэмшвэл зохих ажлын дадлага, ур чадварыг тодорхойлсон сургалтын хөтөлбөрийг талууд харилцан тохиролцож дагалдан суралцагчийн хөдөлмөрийн гэрээнд хавсаргана.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
3 Нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх зорилт			
3.1	Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	МБС-ын салбар дах хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх	63.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх, онолын мэдлэгийг практик дадлагатай хослуулах, ажлын дадлага, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор ажил олгогч, дагалдан суралцах ажилтан, сургалтын байгууллага хамтран дагалдан суралцах гуравласан хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
5. Санхүү, эдийн засгийн хөгжлийн зорилт			
5.1	Сургуулийн хүчин чадлыг	Материаллаг баазын	121.1.Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах,

	нэмэгдүүлэх	ашиглалт, хэрэглээг сайжруулах	ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулна.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
6. Нийгмийн хамгаалал, суралцагчдад чиглэсэн хөгжлийн зорилт			
6.1	Нийгмийн хамгааллыг сайжруулах	Нийгмийн хамгаалал, хариуцлагын сан үүсгэх ашиглах	120.2.Ажил олгогч ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль

№	Чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогч /Хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт/
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
2. Сургах ба сурах үйл ажиллагааны хөгжлийн зорилт			
2.1	Сургалцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх	11.2.Хөдөлмөр эрхлэлтийн сургалт нь ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхдэд богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх зорилготой байна. 11.3.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9.4-т заасан байгууллагатай хамтран хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болно.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
3. Нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх зорилт			
3.1	Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн	МБС-ын салбар дах хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх	6.3.2.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах; 29.9.10.мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх;
3.2	хамтын ажиллагааг өргөжүүлэх	МБС-ын чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	6.3.8.хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр. 7.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
5. Санхүү, эдийн засгийн Говьсүмбэрийн зорилт			
5.1	Сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Материаллаг баазын ашиглалт, хэрэглээг сайжруулах	3.1.11."бизнес инкубацийн үйлчилгээ" гэж хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэхийг хүссэн иргэн, түүнчлэн малчинд мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн байр түрээслүүлэх зэргээр дэмжлэг үзүүлж, аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэхийг. 3.1.12."бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч" гэж 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг.
5.2		Санхүүгийн менежментийг сайруулах, замаар мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	11.4.Энэ хуулийн 11.2-т заасан иргэний сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлнэ. 23.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна: 23.1.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах; 23.1.2.ажилд зуучлах; 23.1.3.хөдөлмөрт бэлтгэх; 23.1.4.хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах; 23.1.5.ажил олгогчийг дэмжих; 23.1.6.нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
6. Нийгмийн хамгаалал, суралцагчдад чиглэсэн хөгжлийн зорилт			
6.1	Суралцагчийн үйлчилгээг сайжруулах	Сурагчдын ая тухтай сурч, амьдрах	6.3.7.мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын суралцагч, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

		нөхцөлийг хангах	
--	--	------------------	--

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

№	Чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогч /Хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт/
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
1. Удирдлага, чанарын баталгаажилтын хөгжлийн зорилт			
1.2	Менежментийн чадамжийг дээшлүүлэх	Сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах	27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.
1.2	Чанарын баталгаажилт	Магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагыг мөрдөх	35.1.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн цех, тасаг, хэсэг, ажлын байр бүрд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина. 35.2.Ажил олгогч дотоодын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах үүрэгтэй. 35.3.Ажилтны төлөөлөгч болон ажилтан нь аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт тавих үйл ажиллагаанд оролцох эрхтэй.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
2. Сургах ба сурах үйл ажиллагааны хөгжлийн зорилт			
2.1	Сургалцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх	27.3.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
3. Нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх зорилт			
3.1	Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	МБС-ын салбар дахь хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх	17.1.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна. 17.6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх харилцааг Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулийн дагуу зохицуулна.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
4. Хүний нөөц, мэдлэг, инновацыг хөгжүүлэх зорилт			
4.1	Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх	Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг сайжруулах	27.3.5.ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих; 27.3.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага хүлээлгэх саналаа ажил олгогчид гаргах;
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
5. Санхүү, эдийн засгийн хөгжлийн зорилт			
5.1	Сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Материаллаг баазын ашиглалт, хэрэглээг сайжруулах	7.2.Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн орчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан байна. 9.1.1. машин механизм, тоног төхөөрөмжийн

			бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг (ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл) нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх; 9.1.2. машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байх; 9.1.3 машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа улсын байцаагчаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх; 9.1.4 машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж байх. 9.3.Цахилгааны тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байна. 13.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.
5.2		Санхүүгийн менежментийг сайруулах, замаар мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	26.2.Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

6. Нийгмийн хамгаалал, суралцагчдад чиглэсэн хөгжлийн зорилт

5.1	Нийгмийн хамгааллыг сайжруулах	Нийгмийн хамгаалал, хариуцлагын сан үүсгэх ашиглах	15.2. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна. 15.3. Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ.
-----	--------------------------------	--	---

Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн бодлого

№	Чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогч /Хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт/
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
2. Сургах ба сурах үйл ажиллагааны хөгжлийн зорилт			
2.1	Сургалцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх	Нефть боловсруулах чиглэл нефтийн инженер, техникийн ажилтан болон ачаа тээврийн чиглэлээр төрөлжсөн мэргэжилтэй ажилтан бэлтгэх /500-800 мэргэжилтэй ажилтны эрэлт байна/ Оёмол сүлжмэл бүтээгдэхүүний цогцолбор бий болгох энэ чиглэлийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх Төмөр замын чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх /Вагон үзэгч, замчин, өртөөний жижүүр, туслах машинист, галт тэрэгний үйлчлэгч зэрэг мэргэжлүүдээр жилд 800-1000 орчим ажилтны эрэлт байна/ Баянтал суманд байгуулагдах тусгай хүчний

			цэргийн ангид мэргэжил олгох сургалтууд зохион байгуулах Зам гүүр хоолойн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх Иргэний болон үйлчилгээний барилга байгууламж чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
3. Нийгмийн түншлэл, нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх зорилт			
3.1	Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх	МБС-ын салбар дахь хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх	Уул уурхайн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх /Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах Кокс-химийн цогцолбор, Нүүрс-Химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Жоншны хүдэр боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулна./ Тээвэр ложисткын бүс болгох /бүх төрлийн уул уурхайн болон ачаа бараа тээвэрлэх/ Цахилгаан эрчим хүч /дулааны станц/, Сэргээгдэх эрчим хүч /Нар, салхин станц/ /Говийн бүсэд нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина. Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина. Чойрт 100 МВт салхи, 40 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ. Багануур-Чойр чиглэлийн 220 кВ, Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ, Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, Сайншанд-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын төслийн бэлтгэл ажлыг хангана. /
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
4. Хүний нөөц, мэдлэг, инновацийг хөгжүүлэх зорилт			
4.1	Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх	Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг сайжруулах	Сургалтын байгууллагын багшлах боловсон хүчнийг чадавхжуулах, ажиллах орчин нөхцөлөөр хангах талаар анхаарах /Багшлах хүний нөөцийг чадавхжуулж цэцэрлэгийн багш 10,000, бага ангийн багш 2,000, ЕБС-ийн багш 11,000, англи хэлний 2,000, МСҮТ-ийн 2,000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ./

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр

№	Чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогч /Хуулийн нэр, зүйл, хэсэг, заалт/
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
2. Сургах ба сурах үйл ажиллагааны хөгжлийн зорилт			
2.1	Сургалцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх	2.5.5. Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн нэгжид ажиллах залуучуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. 2.5.7. Хөдөлмөрийн зах зээлд эрэлт, хэрэгцээтэй ангийг шинээр нээж, шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ			
4. Хүний нөөц, мэдлэг, инновацийг хөгжүүлэх зорилт			
4.1	Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх	Мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх	2.4.1. Эрдэм шинжилгээ судалгааны ажилд залуу инженер, багш нарыг хамруулан дэмжинэ. 2.4.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, орон нутгийн

			эрдэс баялагт түшиглэн инновацад тулгуурласан шинжлэх ухааны судалгаа бүтээлийг дэмжинэ. 2.3.9. Олон улсын болон улсын түвшинд амжилт гаргасан оюутнуудыг урамшуулна. 2.5.4. Гарааны бизнес эрхлэх залуучуудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
--	--	--	---

Дөрөв. Хүчин зүйлсийн зураглалын шинжилгээ

Сургуулийн менежментийн чадамжийн шинжилгээний явцад гадаад дотоод орчныг шинжилж **22 боломж, 17 аюул бэрхшээл**, дотоод орчны 34 **давуу тал, 30 сул талыг** асуудлын болон зорилгын модны шинжилгээ, SWOT шинжилгээний үр дүнгээр нийт 103 хүчин зүйлсийг тодорхойлсон.



Эдгээр хүчин зүйл тус бүр дээр экспертийн шинжилгээ хийж үзэхэд гадаад орчны нөлөөлөл 42,5 хувь, дотоод орчны нөлөөлөл 57,5 хувь байна.

Нөлөөлөл	Тоо	Хувь	
Давуу тал	41	28.1	57.5
Сул тал	43	29.5	
Боломж	37	25.3	42.5
Аюул	25	17.1	
Хүчин зүйлс	146	100.0	

Дүгнэвэл дотоод орчны хүчин зүйл ихтэй байгаа нь стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд сургуулийн удирдлага, хамт олны оролцоо маш их байгааг илтгэж байна.

Стратегийн томъёоллын зураглалаас харвал **“Сул талыг арилгаж боломжийг хүртэх замаар сул талыг багасгаж, аюулаас зайлсхийх”**

А.Х.Мексоны *5Х5* шинжилгээний үр дүнд тулгуурлаж Говьсүмбэр ПК-н бизнесийн орчин, зах зээлийн төлөв байдалд хамгийн чухал 25 хүчин зүйлсийг сонгон стратегийн төлөвлөгөөний 2024-2028 оны хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлов.

Стратегийн гол зорилтыг тодорхойлох мексоны 5х5 шинжилгээ

А.Х.Мексоны *5Х5* шинжилгээний үр дүнд тулгуурлаж хамгийн чухал 25 хүчин зүйлсийг сонгон авч нэн тэргүүн шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхойлж, хөгжлийн стратегийг тодорхойлж байна.

Мексоны асуулт 1. Хамгийн их нөлөөлөх гадаад орчны 5 боломж

- 1.1 **Материаллаг бааз түшиглэн өөрийн үйл ажиллагааны орлого олох**
- 1.2 Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрэлттэй мэргэжлийн хөтөлбөрүүд магадлан итгэмжлэгдэх үйл явц
- 1.3 Хосмог сургалтын тогтолцоо

- 1.4 Ажил мэргэжлийн стандарт, чадамжийн сан
- 1.5 Мэргэжлийн зөвлөлийн хамтын ажиллагаа

Мексоны асуулт 2. Гадаад орчноос нөлөөлөх хамгийн аюултай 5 эрсдэл

- 2.1 Үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшууллын тогтолцоо сул
- 2.2 Мэргэжлийн багш, мэргэшсэн боловсон хүчнийг алдах эрсдэл байна
- 2.3 Эрдэм шинжилгээ, инновац, үйлдвэрлэлийн нэгдсэн хөтөлбөр байхгүй, бүтээлийн хөгжүүлэлт, дата мэдээллийн сан хөгжөөгүй
- 2.4 Инновац, шинэ санаа, мэдлэгийг хөгжүүлэх санхүүгийн боломж муу
- 2.5 Шинэ санаа бүтээлийн талаарх маркетинг, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажил дутмаг

Мексоны асуулт 3. Дотоод орчны хамгийн давуу 5 хүчин зүйлс

- 3.1 Үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай мэргэжилтэй бэлтгэх сургалтын орчин бүрдсэн
- 3.2 Дижитал технологид суурилсан сургалтын программ хангамж, цахим төхөөрөмж, хэрэгсэл ашиглалт
- 3.3 Үндэсний хэмжээнд сургууль магадлан итгэмжлэгдсэн
- 3.4 Эрэлттэй мэргэжлийн хөтөлбөрүүд магадлан итгэмжлэгдэх үйл явц эрчимжсэн
- 3.5 Дэлхийн ур чадварын уралдаанд 2 удаа оролцдог
- 3.6 Нийт багш нарын 50 гаруй % нь магистр болон түүнээс дээш зэрэг дэвтэй

Мексоны асуулт 4. Дотоод орчны хамгийн сул 5 хүчин зүйлс

- 4.1 Нийгмийн түншлэлийн хамтын ажиллагаа сул, салбарын уялдаа холбоо байхгүй, мэргэжлийн холбоод, зөвлөл хоорондын уялдаа хангалтгүй.
- 4.2 Хөндлөнгийн магадлан итгэмжлэл, дотоод чанарын баталгаажилтын тогтолцоо бүрдээгүй
- 4.3 Уурхай, аж ахуй нэгжүүдэд чадварлаг багш нараа алдах
- 4.4 Багш нарын нийгмийн асуудлыг оновчтой шийдээгүй тохиолдолд мэргэжлийн өндөр чадвартай багш нар тогтвор суурьшилтай ажиллахгүй байх
- 4.5 Багш нарын нийгмийн асуудлыг оновчтой шийдээгүй тохиолдолд мэргэжлийн өндөр түвшинтэй багш нар тогтвор суурьшилтай ажиллахгүй байна.

Дөрөв. Хамгийн чухал гэж сонгосон SWOT шинжилгээний 5 хүчин зүйлс:

- ✓ Материаллаг бааз түшиглэн өөрийн үйл ажиллагааны орлого олох
Үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшууллын тогтолцоо сул
- ✓ Нийгмийн түншлэлийн хамтын ажиллагаа сул, салбарын уялдаа холбоо байхгүй, мэргэжлийн
- ✓ Холбоод, зөвлөл хоорондын уялдаа хангалтгүй
- ✓ Материаллаг бааз түшиглэн өөрийн үйл ажиллагааны орлого
- ✓ Дижитал технологид суурилсан сургалтын программ хангамж, цахим төхөөрөмж, хэрэгсэл

Тав. Алсын хараа, эрхэм зорилго

АЛСЫН ХАРАА

**ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД ҮНЭЛЭГДЭХ УР ЧАДВАРТАЙ ҮНДЭСНИЙ
ШИЛДЭГ МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН БЭЛТГЭНЭ**

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэвшилтэт техник, технологи бүхий Үндэсний хэмжээний жишиг Политехник коллеж болно.

ЧАНАРЫН БОДЛОГО

Байгаль орчинд ээлтэй орчныг бүрдүүлж, суралцагч, бусад оролцогч талуудын эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн болон техникийн боловсролын үйлчилгээг үзүүлэх замаар салбар дундын мэргэжилтэй ажилтныг бэлтгэнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

- **МЭРГЭШСЭН БАГШ, АЖИЛТАН**
- **ОЛОН УЛСЫН СТАНДАРТ**
- **МЭДЛЭГ, ИННОВАЦ**
- **ЧАДВАРЛАГ ТӨГСӨГЧ**
- **ОЛОН ТАЛТ НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ**
- **НОГООН ХӨГЖИЛ**
- **ЭВСЭГ ХАМТ ОЛОН**

УРИА

Чадварлаг багш, Чанартай сургалт, Чадамжтай төгсөгч

Зургаа. Стратегийн зорилго, зорилтууд

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Орчин үеийн менежментийн удирдлагын арга барилыг нэвтрүүлэн чанарын болон нэгдмэл хамтын

удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ.

- 1.1 Сургуулийн зохион байгуулалтыг сайжруулах
- 1.2 Чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангах

ХОЁР. СУРГАХ БА СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Сургалт, судалгаа, инновацыг хөгжүүлэн сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

- 2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх
- 2.2 Шаталсан бүтэц болон шинэ технологи бүхий сургалтыг нэвтрүүлэх
- 2.3 Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг хөгжүүлэх
- 2.4 Сурах бичиг, сургалтын орчныг хөгжүүлэх

ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, тогтвортой байдлыг хангана.

- 3.1 Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг сайжруулах
- 3.2 Мэдлэг, технологи, инновацыг хөгжүүлэх
- 3.3 Нийгмийн хамгааллын санг үүсгэх, үр бүтээлтэй ашиглах

ДӨРӨВ. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Нийгмийн түншлэлийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

- 4.1 Нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх
- 4.2 Дотоод, гадаад хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх
- 4.3 Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх

ТАВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах санхүүгийн чадавхыг дээшлүүлнэ.

- 5.1 Төсөв санхүүгийн төлөвлөлт, хэрэгжилт
- 5.2 Материаллаг баазын ашиглалтыг нэмэгдүүлэх
- 5.3 Төсөв, санхүүгийн хяналтыг сайжруулах

ЗУРГАА. Ерөнхий чиг үүргийн нэр: СУРАЛЦАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Суралцагчдын хөгжих, дэмжих үйлчилгээг нэмэгдүүлнэ

- 6.1 Суралцагчийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх
- 6.2 Суралцагчийг дэмжих, оролцоог сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх

ДОЛОО. Ерөнхий чиг үүргийн нэр: ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Чанарын бодлого, зорилго зорилтуудыг хэрэгжүүлж сонирхогч талуудын хэрэгцээг бүрэн хангана

- 7.1 Хяналт үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- 7.2 Чанарын менежментийн тогтолцоог үнэлэх шалгуур үзүүлэлтэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

Бодлогын баримтад тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга зам	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2024	Зорилтот түвшин 2028	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжих хугацаа	Хариуцах эзэн
Нэг. Ерөнхий чиг үүргийн нэр: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО						
Үндсэн чиг үүргийн нэр: <u>Менежментийн чадамжийг хөгжүүлж, бэхжүүлнэ.</u>						
Зорилт 1.1. Сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах						
1.1.1. Стратеги төлөвлөгөөг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх	Хэрэгжилтийн хувь	Говьсүмбэр ПК-н хамт олноос сургуулийн 2019-2023 оны ерөнхий чадамжийн өөрийн үнэлгээний үндсэн 7 үзүүлэлтийн дундаж 70,6 хувь буюу “САЙН” гэж үнэлэгдсэн байна.	Хэрэгжилт 100% Аливаа үйл ажиллагааны гүйцэтгэлд дүн шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, байнгын сайжруулалтыг хийж хэвшсэн байна.	5,500.0	Жил бүр	СУЗ 33
1.1.2. Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулах, хөгжүүлэх, танилцуулах, хэрэгжүүлэх	Боловсруулагдсан дүрэм, журам	2024 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар 11 дүрэм, журам сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байна.	Сургуулийн хэмжээнд эрсдлийн үнэлгээг жилд 1 удаа хийж, шаардлагатай дүрэм журмын хэрэгцээг тодорхойлж, шинээр болон шинэчлэн сайжруулсан 2-оос доошгүй дүрэм журам батлуулсан байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	33 ISO баг
1.1.3. Сургуулийн удирдлагын эрх, үүргийн матрицыг шинэчлэх, албан тушаалын тодорхойлолтыг боловсронгуй болгох	Мэдлэгийн менежментийг нэвтрүүлэх Процессын зураглал Албан тушаалын тодорхойлолт боловсруулах	20 ажлын байрны тодорхойлолт боловсруулагдсан байна. Ажил үүргийн давхардал байна.	Ажил үүргийн давхардлыг арилгаж, 24-н ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, баталсан байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	ЗАА, СА Хүний нөөц
1.1.4. Цахим тоног төхөөрөмж ашиглалтыг сайжруулах /хурал зөвлөгөөн, цахим болон зайн сургалт хийх/	Цахим тоног төхөөрөмжийн хүчин чадалыг нэмэгдүүлэх Цахимаар хийх	МУЗГ-ын санхүүжилтээр цахим тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.	Удирдах зөвлөлийн хурал– 2 удаа, Захирлын зөвлөлийн хурал–	323,240.0	Жил бүр	33 CA IT

	боломжтой хурал, зөвлөгөөн, сургалтын хэрэгцээг тодорхойлох		6-аас доошгүй удаа, хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд–2-оос доошгүй удаа үр дүнтэй хурал зөвлөгөөн, сургалтыг хэрэгжүүлж хэвшсэн байна. Цахим болон зайн сургалтын анги шинээр нээж туршсан байна.			
1.1.5. Байгууллагын нийтлэг үйлчилгээний журмыг нэвтрүүлэх	Батлагдсан Байгууллагын нийтлэг үйлчилгээний журам	Дотоод журмаар зохицуулагддаг.	Байгууллагын нийтлэг үйлчилгээний 3-аас доошгүй журмыг боловсруулж, мөрдөж хэвшсэн байна. Байгууллагын соёл төлөвшсөн байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	33 ЗАА
<u>Зорилт 1.2. Чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангах</u>						
1.2.1 “Тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй сургууль” бодлогыг хэрэгжүүлэх	“Тогтвортой хөгжлийн зорилго-4” Суралцагчдын суралцахуйн алдагдлыг тодорхойлсон байна. Сургалтын ахиц дэвшлийг хэмжсэн байна. Нэгтгэн дүгнэх зорилгоор суралцагчийн үнэлгээний хэрэгслийг боловсруулж ашигласан байдал.	Тусгайлсан бодлого хэрэгжүүлж ажиллаагүй.	Суралцагч бүр хүлээн зөвшөөрөгддөг, хүндлэгддэг, үнэлэгддэг гэдгээ мэдрэх боломж олгосон тэгш хүртээмжтэй, эрүүл аюулгүй орчинд чанартай боловсролыг эзэмшиж, тэгш бус байдал арилсан байна. Жендэрийн ялгаа болон ялгаварлан гадуурхалт	Батлагдсан төсөв	Жил бүр	ЗАА, СА СНА

			арилсан байна.			
1.2.2 Байгууллагын магадлан итгэмжлэлд орох	Магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага	2022 онд 5 жилээр магадлан итгэмжлэгдсэн.	2027 онд 5 жилээр дахин магадлан итгэмжлэгдсэн байна.	15,000.0	2027-2028 онд	Сургуулийн Магадлан итгэмжлийн комисс
1.2.2. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэл хийлгэх	Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн хөтөлбөр	2 хөтөлбөрийг магадлуулахаар өөрийн үйл ажиллагааны эхний тайлан өгсөн.	2025 онд 2, 2026 онд 1, 2027 онд 1, 2028 онд 1, Нийт 5-аас доошгүй суралтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн байна.	25,000.0	2025-2028 онд	СА
1.2.3 ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо ОУ-ын стандартыг нэвтрүүлэх, баталгаажуулах	Чанарын менежментийн тогтолцоо стандартын шалгуур шаардлага	2024 оны 02 дугаар сараас нэвтрүүлж эхэлсэн.	Чанарын баталгаажилтын тогтолцоо бүрдсэн, ISO ОУ-ын стандартыг баталгаажуулсан байна.	15,000.0	2024-2025 онд	33 СА 3AA
1.2.4 ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ОУ-ын стандарт нэвтрүүлэх, баталгаажуулах	Сургалтын чанар	2024 оны 02 дугаар сараас нэвтрүүлж эхэлсэн.	Суралцагч ба бусад үр шим хүртэгсэд сэтгэл ханамжтай болсон байна. ISO ОУ-ын стандартыг баталгаажуулсан байна.	15,000.0	2024-2025 онд	33 СА
1.2.5 Бүтээмжийг нэмэгдүүлэх “САБ” (сайн арга барил) болон 5C тогтолцоо хэрэгжүүлэх, бүрдүүлэх	“САБ” (сайн арга барил) болон 5C тогтолцооны шалгуур шаардлага	ХАБЭА-н эрсдлийн үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилладаг.	“САБ” (сайн арга барил) болон 5C тогтолцоог хэвшүүлсэн байна.	5,000.0	Жил бүр	ISO баг Эко зөвлөл ХАБ,ЭА
1.2.6 Багш, суралцагчдын ногоон хөгжлийн боловсролыг дээшлүүлж, “Ногоон Мэргэжлийн боловсрол” ойлголтыг нэвтрүүлэн “ЭКО СУРГУУЛЬ” ОУ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Тогтвортой хөгжлийн 17 зорилго “Эко сургууль” ОУ-ын хөтөлбөрийн шалгуур шаардлага	Олон улсын “Эко сургууль” хөтөлбөрийн мөнгөн гэрэгэ өргөмжлөлтэй.	Ногоон хөгжлийн бодлогыг байгууллагын үйл ажиллагаа бүрт хэрэгжүүлж “Эко сургууль” ОУ-ын хөтөлбөрийн алтан гэрэгэ, “Ногоон туг”-ийг гардаж авсан	9,000.0	2025-2027 онд	Эко зөвлөл

			байна. ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо ОУ-ын стандартын шалгуур шаардлагыг тодорхой хэмжээнд хангаж Эко, Ногоон хөгжлийн бодлогын эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.			
Хоёр. Ерөнхий чиг үүргийн нэр: СУРГАХ БА СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД						
Үндсэн чиг үүргийн нэр: <u>Сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.</u>						
<u>Зорилт 2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх</u>						
2.1.1. “Үндэсний хэмжээний ур чадвар” -ын уралдаанд амжилттай оролцох	Техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материалын шаардлага Монгол ур чадварын амжилт	Гагнуур, автомашин, цахилгаан, токарийн 4 мэргэжлээр оролцдог.	Монгол ур чадварт 4 төрлөөр амжилттай оролцсон байна. Эксперт багш, оролцогч хүүхдийн тоо нэмэгдэж, амжилт гаргасан байна.	48,000.0 /1 мэргэжилд 7,000.0/	2025-2027 онд	СА
2.1.2. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн гүйцэтгэл, үр нөлөөг үнэлж, сайжруулалтыг үе шаттай хийх	ЧССХ-ийн шалгуур шаардлага ААНБ, ажил олгогч, ИТА нарын санал	Хөтөлбөрийн сайжруулалт хийгддэг. Хөтөлбөрүүд дээр үе шаттай дүн шинжилгээ хийх шаардлагатай.	ААНБ, ажил олгогч нарын хэрэгцээ шаардлагыг хангасан 15 мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг ИТА- нуудтай хамтран шинэчлэсэн байна.	20,000.0	Жил бүрийн 6 сард	СА Хамтран ажиллагч ААНБ-ууд
2.1.3. Бүс орон нутгийн хэмжээнд эрэлттэй тэргүүлэх мэргэжлүүдээр шинэ мэргэжилийн эрх авах, мэргэшлийн түвшний шаардлагад нийцсэн үндэсний	БЕХ-ийн 26-р зүйлийн 26.1.21, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3, 5.4-р зүйл,	Тусгай зөвшөөрөл дээрх 15 мэргэжлийн хөтөлбөртэй.	Эрчим хүч, аж үйлдвэр, хөнгөн үйлдвэр, төмөр зам, соёл урлагын чиглэлээр шинээр 2 анги нээсэн	2,450.0	2025-2028 онд	СА

мэргэшлийн шаталсан бүтцийн уялдааг хангасан сургалтын хөтөлбөр боловсруулах			байна.			
2.1.4. Насанд хүрэгчид болон тусгай хэрэгцээт бүлэгт зориулсан мэргэжлийн чадамж олгох төрөл бүрийн хэлбэртэй сургалтыг зохион байгуулах	Богино хэмжээний түр сургалтын шалгуур шаардлага	Баруун бүсийн сургалтын төв ХХК-тай хамтран вагон үзэгч, өртөөний жижүүр бэлтгэх богино хугацааны сургалт зохион байгуулж, 55 суралцагч хамрагдаж, ажлын байранд гарсан.	Төрийн болон хувийн хэвшлийн ААН-ийн захиалгаар мэргэжилтэй ажилчдад мэдээлэл технологи, мод үржүүлэг, автозам, төмөр замын чиглэлээр мэргэжлийн сургалт зохион байгуулна. Тусгай хэрэгцээт иргэдэд чиглэсэн богино хугацааны сургалтыг ХХҮГ-тай хамтран зохион байгуулсан байна.	Хувьсах зардал	Жил бүр	СА ХХҮГ
2.1.5. Хичээлийн агуулга, хэлбэр (content)-ийг хөгжүүлэх мультмедиа багийг бүрдүүлж мульт медиа дижитал технологи бүхий цахим хичээлийг хөгжүүлэх	Цахим хичээлийн сан, ашиглалт	15 ээлжит хичээлийн цахим хичээл боловсруулагдсан. Багш, суралцагчдын цахим ур чадварын түвшинг тодорхойлох шаардлагатай.	Цахим хичээлийн сан, ашиглалт - Иж бүрэн 3 хичээл - Ээлжит хичээлийг багш бүр дээр 3-аас доошгүй. Контентийн тоо - 8 Багш, суралцагчдын цахим ур чадварын өсөлт нэмэгдсэн байна. Цахим хичээл хөгжүүлэлтийн багтай болсон байна.	20,000.0	2025-2028 онд	СА Цахим хөгжүүлэлтийн баг
2.1.6. Багш хичээл сургалт, дадлагын цагийг үр дүнтэй ашиглаж,	Ээлжит хичээлийн хяналт	Нэгж хичээлийн хөтөлбөрийн батлалт	Суралцагчдаас санал асуулга,	22,500.0	Хичээлийн жил	СА

сургалтын агуулгыг суралцагчдад бүрэн эзэмшүүлэх, СА хяналт үнэлгээг сайжруулах	Цаг бүртгэл Камерийн хяналт	Цагийн бүртгэл	явцын, хөндлөнгийн шалгалтыг хичээлийн жилийн эхэнд, төгсгөлд авч багшийн үр дүнг суралцагчын өсөлтийн хувиар үнэлж хэвшсэн байна.		бүрийн 1, 3 дугаар улиралд	
2.1.7. Нийгмийн түншлэл, сонирхогч талуудтай хамтран захиалгат сургалтыг гүйцэтгэх	Хамтарсан сургалт зохион байгуулсан ААНБ-ын тоо Төгсөгчдийн тоо	2024 онд 2 байгууллагатай хамтран сургалт хийсэн.	Жил бүр 2-оос доошгүй ААНБ-ын захиалгат сургалтыг зохион байгуулж, 60-аас доошгүй хүнийг сургаж, мэргэжил олгосон байна.	16,800.0	Жил бүр	СА НТАЗ
2.1.8. Богино хугацааны хөтөлбөрт дүгнэлт авч зохион байгуулах	Богино хугацааны түр сургалтын шалгуур шаардлага	7 мэргэжлээр богино хугацааны сургалт явуулах, дүгнэлт авахаар хөтөлбөрийг боловсруулан хүргүүлсэн.	7 мэргэжлээр богино хугацааны сургалт зохион байгуулах, хөтөлбөрийн дүгнэлт авч 4-оос доошгүй сургалт явуулсан байна. Нэмэлт мэргэжлээр дүгнэлт авах шаардлага гарч ирвэл тухай бүрт нь авч, сургалт зохион байгуулсан байна.	5,000.0	Жил бүр	СА
2.1.9. Хосмог сургалтыг зохион байгуулах	Дүрэм журмын шалгуур шаардлага	Хуульд шинээр тусгагдсан заалт	Ажил олгогчийн захиалгаар хосмог сургалтыг 4-өөс доошгүй удаа чанартай зохион байгуулж, мэргэжилтэй ажилтан бэлтгэсэн байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	СА
Зорилт 2.2. Шаталсан бүтэц болон шинэ технологи бүхий сургалтыг нэвтрүүлэх						

2.2.1. Шаталсан сургалтыг хэрэгжүүлж, чанар, үр өгөөжийг дээшлүүлэх	Дүйцүүлсэн хөтөлбөр Дэвшин суралцсан суралцагчдийн тоо	Их дээд сургуультай хөтөлбөр дүйцүүлсэн, гэрээгээр шатлан суралцуулсан суралцагч байхгүй боловч багш нарыг дүйцүүлэн сургаж байна.	Их дээд сургуульд суралцагчийн тоон судалгааг гаргаж, тоог ахиулах, МБ-ын сургалтаас ТБ-ын сургалтад шатлан суралцагчдын тоог нэмэгдүүлэх.	Батлагдсан төсөв	Жил бүр	СА
2.2.2. Ахлах сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Дүрэм журмын шалгуур шаардлага	Дүрэм журам судалж байна.	Магадлан итгэмжлэгдсэн 2 хөтөлбөрийг ахлах сургуулийн хөтөлбөрт хэрэгжүүлэх ажлыг дүрэм журмын дагуу эхлүүлсэн байна.	Батлагдсан төсөв	2025-2028 онд	СА
2.2.3. Коосэн болон Pearson хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар сургалтын шинэ технологийг нутагшуулах	Коосэн болон Pearson хөтөлбөр шалгуур шаардлага	Судалж байна.	Коосэн болон Pearson хөтөлбөрийг тус бүр 1 мэргэжил дээр нэвтрүүлж, сургалт эхэлсэн байна.	Батлагдсан төсөв	2025-2028 онд	СА
Зорилт 2.3. Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг хөгжүүлэх						
2.3.1. Судалгаа хөгжүүлэлтийн журмыг боловсруулж хэрэгжүүлэх	Журам	-	Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж хэвшсэн байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	СА
2.3.2. Мэргэжлийн зэрэг, боловсролын цол ахиулах судалгаа, арга зүйг дэмжих урамшууллын хөшүүргийг нэвтрүүлэх	Үйлдвэрчний эвлэлийн хороо Хамтын сан	Суралцах хугацаанд цалинтай чөлөө олгодог.	Зэрэг, цолоо ахиулсан багш, ажилчдын тоо. Санхүүжилтын хэмжээ нэмэгдсэн байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	ЗАА ҮЭ
2.3.3. Багш нарын дунд инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхыг бэхжүүлэх	Эрдэм шинжилгээний хурал, бүтээл	Жил бүр инноваци шингэсэн бүтээл, илтгэлийн уралдааныг зохион байгуулдаг.	Эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн чанар, үр өгөөжийг дээшлүүлсэн байна. Улс, бүс, аймагт шалгарсан эрдэм	1,500.0	Жил бүрийн 4 дүгээр улирал	СА

			шинжилгээний бүтээлийг хэвлэж, хичээл сургалтад ашигласан байна.			
2.3.4. Суралцагч ба бусад сонирхогч талуудын хэрэгцээ хүлээлтийг тодорхойлох, ойлгох, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийж, үр дүнг тодорхойлох	Сайн боловсруулсан асуулгын хуудас	Суралцагч нараас сургалтын орчны судалгаа, ОХХ-ны үйлчилгээний судалгаа, багш, ажилтнуудаас ажлын байрны болон үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа авсан.	Суралцагч болон сонирхогч талуудын хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамж тодорхой болсон байна. /жил бүр сайжруулах/	500,000	Жил бүр	СА Судалгаа, шинжилгээний баг
2.3.5. Суралцагчдын хувь хүний санхүү, интерпенершип хичээл МБС-д заах болсонтой холбоотой төсөл боловсруулах үр чадварыг хөгжүүлэх, инноваци шингэсэн бүтээлийн уралдаан, туршилт судалгааг хөгжүүлэх	Үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж бүхий инновацийн бүтээгдэхүүн	Багш, оюутны хамт зохион байгуулдаг. Төгсөлтийн өмнөх төсөлт ажил болгож зарлаж хэвшсэн.	Инноваци шингэсэн бүтээл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо. Өөрийн үйл ажилллагааны орлого нэмэгдсэн байна.	34,020.0	Жил бүр	СА
2.3.6. Ажил мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөр, үнэлгээний төлөвлөгөө боловсруулах мэргэшсэн багтай болох	Ажил мэргэжлийн стандарт Сургалтын хөтөлбөр, Үнэлгээ, баталгаажуулалтын ажилтны шалгуур шаардлага	Үнэлгээ баталгаажуулалтын ажилтан 2 багш, үнэлгээний ажилтан 17 багш, ажилтан бэлтгэгдсэн.	Ажил мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, баталгаажуулалтын 5 хүний бүрэлдэхүүнтэй мэргэшсэн багтай болсон байна.	2,250.0	2025 онд	СА
2.3.7. Боловсролын салбарын цахим мэдээллийн системийг ашиглах, хэрэгжүүлэх	Боловсролын яамнаас МБ-ын салбарт ашиглаж байгаа цахим систем	E-TVET.MN, MBS.EES.MN ашиглаж байна	2024 оны 12 дугаар сарын 23-ны А/2866 тоот чиглэл хавсралт журам, шаардлагын дагуу ажиллаж эхэлсэн байна. Мөн төрийн албаны ERP системийг бүрэн нэвтрүүлсэн байна.	30,000.0	2025-2028 онд	СА

Зорилт 2.4. Сурах бичиг, сургалтын орчныг хөгжүүлэх

2.4.1. Сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг сайжруулах, шинээр боловсруулах	6628 гарын авлага хэрэглэгдэхүүнтэй.	Үндэсний хэмжээний сурах бичиг, гарын авлага 3, багшийн гарын авлага 3, 38 багшийн 6480 тараах материал, 11 багшийн орчуулгын 19 гарын авлага, 48 багшийн 126 ширхэг сурах бичиг, гарын авлагатай.	Багш нарын боловсруулсан гарын авлагын тоог 1,5 хувиар өсгөсөн байна.	Жил тутам сургуулийн нийт төсвийн 3%	2025-2028 онд	CA CA3H
2.4.2. Номын сангийн фондын баяжилтыг мэргэжлийн болон ерөнхий эрдмийн, бусад хөгжлийн номоор бүрэн хангах	1174 төрөл ангийн 12103 ширхэг номтой.	Ерөнхий эрдмийн 15 төрлийн 663 сурах бичиг 5,5 хувийг, мэргэжлийн ном 6479 ширхэг 53,5 хувийг эзэлж байна.	2025-2028 онуудад Ерөнхий эрдэм 15 төрлийн 300 ном 2,5 хувь, Мэргэжлийн ном 17 төрийн 300 ширхэг ном 2,5 хувь, Уран зохиол, танин мэдэхүйн, сэтгэн бодох, хувь хүний хөгжлийн ном 2 хувиар тус тус жил бүр өссөн үзүүлэлттэй болсон байна.	Жил тутам сургуулийн нийт төсвийн 3%	2025-2028 онд	CA Номын санч
2.4.3. Мульт медиа дижитал технологид суурилсан дэвшилтэт технологи бүхий сургалтын орчныг хөгжүүлэх	Lib4U номын сангийн үүлэн технологид суурилсан цогц програм хангамжтай.	Lib4U номын сангийн цогц програм нь электрон номын сан, электрон каталог байгуулах, номын сангийн хөмрөгт байх ном, тогтмол хэвлэл, эрдмийн ажил, аудио видео гэх мэт материалуудыг бүртгэх, зураасан кодын тусламжтайгаар номын сангийн үйлчилгээ, тооллого хийх үйл ажиллагааг	Цахим мэдээллийн сан үүсгэх техник тоног төхөөрөмжийн судалгаа хийж, техникийн тодорхойлолт, үнийн судалгаа болон ном хэвлэлийг цахим хэлбэрт оруулах аргачлал, төлөвлөлт зохион байгуулалтыг гарган ажиллаж,	Цахим ном худалдан авах 400.000, Скайнер 1,800.000, зөөврийн компьютер 3,000.0, цахимжуулсан номын эхийг хадгалах хард диск 900.000	2025-2028 онд	CA

		автоматжуулах, номын сантай холбоотой төрөл бүрийн тайлан, статистик мэдээллээр 100% хангагдсан.	ном, хэвлэлийг цахим хэлбэрт шилжүүлэх, шаардагдах төсвийн төсөөлөл боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд худалдан авалтыг зохион байгуулсан байна.			
Гурав. Ерөнхий чиг үүргийн нэр: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД						
Үндсэн чиг үүргийн нэр: <u>Хүний нөөцийг хөгжүүлж, чадамжийг дээшлүүлнэ.</u>						
<u>Зорилт 3.1. Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг сайжруулах</u>						
3.1.1. “Багшийн хөгжил” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах замаар чадамжийн түвшнийг ахиулах	“Багшийн хөгжил” - ийн төлөвлөгөө 2024	Багшийн хөгжлийн хөтөлбөр байхгүй	“Багшийн хөгжил” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	ЗАА, СА, Багш нарын зөвлөл
3.1.2. Үйлдвэр, аж ахуйн газарт нэвтэрч байгаа шинэ техник, технологийг эзэмшүүлэх зорилгоор багш-инженер солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	Шинэ техник технологийн судалгаа Багш-инженер солилцооны хөтөлбөр	ИТА-ыг урьж дадлагын тайлан хамгаалалт төгсөлтийн диплом хамгаалалтанд оролцуулж хэвшсэн.	Багш-инженер солилцооны хөтөлбөрийг боловсруулж, жилд 3-аас доошгүй багш ИТА-ны солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	2,400.0	Жил бүр	ЗАА, СА
3.1.3. Багш бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэх	Журам боловсруулж, хэрэгжүүлсэн байдал	Бодлогын баримт бичиг байхгүй.	Багшийн 3-н тулгуурт бодолгыг хэрэгжүүлж ажилласан байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	СА, Багш нарын зөвлөл
3.1.5. Багшийн чадамжийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлж, дутагдалтай чадамжийг дээшлүүлэхэд суурилсан сургалт хөгжүүлэлт хийх	Үнэлгээний шалгуур үзүүлэлт Сургалтын хөтөлбөр	Үнэлгээ хийгдээгүй байна.	Багш ЧССХ-ийн хүрээнд мэргэшлийн өндөр мэдлэгтэй болсон байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	СА САЗН
3.1.6. Залуу багш нарын дадлагажуулах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	“Шинэ ажилтны хөтөлбөр”	Хөтөлбөр байхгүй.	Шинэ багш, ажилтан дадлагажуулах хөтөлбөрийг	5,000.0	Тухай бүрт	ЗАА, СА

			боловсруулж, хэрэгжүүлсэн байна.			
3.1.7. ХАБЭА-н мэргэшсэн, зөвлөх мэргэжилтний баг бүрдүүлж ХАБ-ын соёлыг багш, ажилчид, суралцагчдад төлөвшүүлэх	ХАБ-ын багийн мэдлэг чадвар, мэргэшсэн байдал, гэрчилгээжүүлэлт Эрсдлийн үнэлгээ хийх чадвар	Сургуулийн ХАБЭА ахлах ажилтан болон багш нар аймгийн ОБГ-тай хамтран сургуулийн эрсдлийн үнэлгээг хийсэн.	Мэргэшсэн багтай болж, ХАБЭА-н мэдлэг чадвар, хандлага, соёлыг төлөвшүүлсэн байна.	30,000.0	Жил бүр	ЗАА, СА
Зорилт 3.2. Мэдлэг, технологи, инновацыг хөгжүүлэх						
3.2.1. Эрдэм шинжилгээний бүтээл, патент, ашигтай загварын гэрчилгээ авах	Эрдэм шинжилгээний бүтээл, патент	Нэг бүтээл дээр ашигтай загварын гэрчилгээ авсан.	Суралцагчдын төгсөлтийн ажлын бүтээлээр 4-өөс доошгүй патент, ашигтай загварын гэрчилгээ авах. Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийг хэвлэж, олон нийтэд түгээсэн байна.	Батлагдсан төсөв	Жил бүр	ЗАА, СА
3.2.2. Бичил үйлдвэрлэл, гарааны компани, бизнес инкубатор төвийг хөгжүүлэх	Бичил үйлдвэрлэл, гарааны компани, бизнес инкубатор	-	Бичил үйлдвэрлэл, гарааны компани, бизнес, инкубатор төв шинээр байгуулах. Багш, оюутан суралцагчдыг өөрөө өөртөө ажлын байр бий болгох ажилд дэмжлэг үзүүлэх, төсөл бичих арга зүйгээр хангаж ажилласан байна. ХХҮГ-аас гарааны бизнесийн зээлд хамруулсан байна.	40,000.0	Жил бүр	ЗАА, СА ХХҮГ
3.2.3. Багшийг тасралтгүй хөгжүүлэх, өөр мэргэжлээрээ хөрвөх боломжийг нэмэгдүүлэх	Мэргэшлийн түвшин 3-5 жилийн элсэлтийн квотын	Хөрвөх боломжтой багшийн судалгааг гаргах	Мэргэшлийн түвшиний хөгжил хөрвөх мэргэжил	Өөрийн орлогоор	Жил бүр	ЗАА, СА

